

“МОНГОЛ ТУЛГАТНЫ ЗУУН ЭРХЭМ” НЭВТРҮҮЛЭГ МОНГОЛЫН
НИЙГМИЙН ОЮУН САНААНЫ ХИЛ ХЯЗГААР БИШ...

Д.Нарантуяа*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: “Монгол тулгатны зуун эрхэм”, нийгмийн оюун санаа, эвдэгч, мэргэжлийн ёс зүй, задрал, найруулагч

“**М**онгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг монголчууд бидний үзэх дуртай, нэр хүндтэй нэвтрүүлэг мөн. Гэвч “үздэг, нэр хүндтэй нэвтрүүлэг” гэдэг хэдэн үгээр энэ нэвтрүүлгийн агуулга зорилго, мөн чанар, нийгмийн оюун санаанд нөлөөлж буй эерэг сөрөг нөлөөлөл, сэтгүүл зүйн мэргэжлийн хандлага, хөгжилд ямар үүрэг гүйцэтгэж буй талаар бодож эргэцүүлэхгүй, шүүн тунгаахгүйгээр дур зоргоор нь орхиж болохгүй юм. Хэр олон хүн сонирхож байна төдий чинээгээр “зөв буруу, болох болохгүйн шүүлтүүрээр шүүх” мэдлэг оюуны хэрэгцээ өснө гэсэн үг. Тиймээс 21 дүгээр зууны Монголын телевизийн хөгжлийн түүхэнд “шинэ үзэгдэл” болоод буй “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлгийн талаар дараах гурван үндэслэлээр шүүмж тэрлэж байна.

1. “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монголын сэтгүүл зүйн үлгэр жишээ бүтээл биш харин найруулагч Баатарын стандарт бус мэдрэмжийн илэрхийлэл.

2. “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монголын нийгмийн оюун санааны хил хязгаар биш харин Баатар найруулагч болон тэдний багийн мэдлэг боловсролын хил хязгаар

3. “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монголын өнгөрсөн одоо ирээдүйг хэлхэж, улс орноо бүтээлцсэн эрхэм хүмүүсийн хувь заяаны цадиг гэхээсээ илүү нэг хүний хүмүүжил ёс суртахууны, улс төрийн үзэл хандлагын тулгалт болж эхлэв.

Тиймээс энэ цаг үед, энэ улс оронд иргэн нь болж төрснийхөө хэргийг гаргаж, мэдлэг ухаанаар зүг чигээ хийгч сэхээтний тоонд багтах гэж хичээн мэрийж, нийгмийн оюун санааг зөв чиглүүлэх үүргээ ухамсарлан, Монголын сэтгүүл зүйн түүхийг бичилцэж, телевизийн салбарт оюунт ухамсараа зориулсан хувь уран бүтээлчийнхээ хувьд хэдэн үг хэлэхээр шийдэв.

1. *“Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монголын сэтгүүл зүйн үлгэр жишээ бүтээл биш харин найруулагч Баатарын стандарт бус мэдрэмжийн илэрхийлэл:*

“Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг эхлэхэд Баатар найруулагчийг “мундаг” гэж бодож байлаа. Мундаг гэснээс “мундаг” гэдэг үгийг хэл

шинжлэлийн ухааны доктор профессор С.Дулам “мунхаг” гэсэн үгнээс гаралтай учраас “мундаг” гэх нь магтаал биш хэмээсэн байна билээ. Тиймээс Баатар найруулагчийг “мундаг” гэхивэл “мунхаг” хэмээн ёжилсон хэрэг болно. Зүгээр л “сүрхий сэргэлэн найруулагч” гэе. Түүнийг сүрхий гэх болсноо тайлбарлах нь зүйн хэрэг.

Баатар найруулагч “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлгийн найруулгаараа:

- Телевизийн найруулагчдын хэвшмэл сэтгэлгээг эвдэж, “Баатар”-ын гэх найруулах урлагийг бий болгосон.
- Телевизийн ярилцлагын тогтсон хэв маягийг эвдэж, “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлгийн гэж хэлж болохуйц хөрөг ярилцлагын “холимог” төрөл жанрыг бий болгосон.
- Техник технологийн хөгжил дэвшлийн араас хөөцөлддөг ядуу сэтгэлгээг эвдэж, орчин үеийн телевизийн өндөр хүчин чадалтай камер, тоног төхөөрөмж ашиглаж “сайн дүрс” үзүүлж чадна гэдгийг батлан харуулсан.
- Стандарт тайз, засал чимэглэл, дүр дүрслэлийн аргыг эвдэж, сонирхолтой шийдлүүдийг ашигласнаар телевизийн бүтээлийн хөгжилд “шинэ үзэгдэл” болж, тодорхой хувь нэмэр оруулсан.
- Баатар найруулагч хийж буй бүтээлээ сурталчлан таниулдаггүй хэт даруухан эсвэл хэт баригдмал хандлагыг эвдэж үзэгчдэд хүлээлт үүсгэх менежмент хийсэн. Хэрвээ санаж байгаа бол “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг гарахаас сарын өмнө Б.Лхагвасүрэн найрагч, хэн нэгэн үзэсгэлэнт бүсгүйн хамт авхуулсан том, том зурагт самбарууд хотын хөл хөдөлгөөн ихтэй гудамжнуудад тавигдаж, хүмүүс “энэ юу юм бол, хэзээ эхлэх юм бол, Лхагвасүрэн

гуайн хажууд ямар учиртай эмэгтэй байгаа юм бол” гэж гайхдаг байсныг. Тэр бол бүтээлээ сурталчлан таниулдаггүй байдлыг эвдэж, үзэгчдийн дунд хүлээлт бий болгосон бас нэг шийдэл байсан.

- Баатар найруулагчийн дараагийн бас нэг “эвдэлт” нь мэргэжил нэгт нөхдийнхөө нэр хүндийг улс төр, бизнесийн бүлэглэлийн дунд өсгөж, уран бүтээлийн маркетинг хийх аргад үлгэрлэн дагуулсан явдал. Уран бүтээлчид ядуу байдаг амьдралын тогтсон ойлголтыг эвдэж, сайн бүтээл хийж ашиг орлоготой, алдар хүндтэй амьдарч болно гэдгийг харуулах явцдаа гаргасан хамгийн том алдаа нь улс төр бизнесийн бүлэглэлтэй гар барин дотносож, дараа үеийнхэндээ буруу замаар будаа тээхийг биечлэн үзүүлсэн явдал. Нэг талаас нь харвал ядарсан хэдэн уран бүтээлчдийнхээ ханшийг өсгөсөн. Харин нөгөө талаас нь харвал Монголын сэтгүүл зүйг худалдан авах сонирхлыг гал мэт ноцоосон байдаг.
- “Баатарын найруулах урлаг” гэгч тусгай нэршил сонсогдох болж, телевизийн найруулагчдыг үнэлэх үнэлэмжийг эвдэн шинэчилж, залуу найруулагчдын дунд уран бүтээлч сэтгэлгээний эрэл хайгуул хийх шинэ манлайллыг бий болгож чадсан Баатар гэгч хүний хийсэн бүтээл сонин содноос гадна өөрөө ч бас шинэ цагийн шинэ хүний өвөрмөц сонирхолтой дүр төрх юм.

Эндээс харвал “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг телевизийн найруулагчийн “найруулах урлаг”-т шинэ хуудас болсон нь маргашгүй.

Ингэж хувь хүнийхээ хувьд өөрийгөө нийгэмд таниулж, авьяас мэдрэмжээ гайхуулсан Баатар найруулагчийн

“Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлгийн зорилго, агуулга, хэлбэр хийц, төрөл жанр, үзэл баримтлал, алсын хараа нь телевизийн болон мэргэжлийн сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлагад эерэг сөрөг ямар үр дагавар авч ирсэн бэ?

Баатар найруулагч үзэгчдийн анхаарал, итгэл үнэмшлийг татахын тулд мэргэжлийн сэтгүүлч - мэргэжлийн хөтлөгч байдаг тогтсон ойлголтыг эвдэж, олны танил, нэр алдартай хүмүүсээр нэвтрүүлгээ хөтлүүлж эхэлсэн. Урлаг соёлын алдартнууд бүр заримдаа спортын од, улс төрийн зүтгэлтэн ч хөтөлж үзлээ. Магадгүй эндээс сүрхий найруулагчийн маань “эвдсэн” олон амжилтуудын зарим нь буруугаар эргэсэн байх. Мэргэжлийн хил хязгаарыг зөрчихөөс мэргэжлийн ёс зүйг зөрчих эхлэл тавигдаж, “Монгол тулгатны зуун эрхэм” Монголын сэтгүүл зүйн түүхэн дэх томоос том анхаарлын тэмдэг болов. Мэргэжлийн бус хөтлөгчдийн мэргэжлийн ёс зүйгүй үг хэллэг, ёс зүйгүй үлгэр дуурайлал нь бидэн шиг “нийгэм журам” байгуулах гэж бэдчиж, ёс зүй, гоо зүйн хэм хэмжээнд амьдарч сурах гэж яваа үндэстний оюун санаанд гэмтэл учруулж, хэлсэн үг, үзүүлсэн үйлдэл бүхнийг нь “үнэн, зөв” хэмээн итгэж хүндэтгэдэг эрхмүүдийн амнаас унасан бүхэн залуу хойч үеийнхнийхээ тархинд сөрөг хандлагын үрийг тарьж үлдээв. Энэ тухай цөөнгүй уран бүтээлчид, үзэгчид үзэл бодлоо илэрхийлснээс цаг хугацааны дарааллыг харгалзан дараах шүүмжүүдийг онцлон харьцууллаа.

Өдрийн сонин 2015.07.24
Г.Баярсайхан “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монголын сэтгүүл зүйг гутааж дууслаа гарчигтай шүүмжид: *...Монголын телевизийн урлагт нэгэн дэвшил байлаа. Ялангуяа*

нэвтрүүлгийн зураг авалт, дуу дүрсний өнгө, өвөрмөц шийдэл зэрэг нь мэргэжлийн өндөр түвшинд хийгдэж буй нь мэдрэгддэг. Энэ бол техникийн талын зүйл юм. Харин нэвтрүүлгийн гол амин сүнс нь болох хөтлөгчид нь сэтгүүл зүйн боловсрол эзэмшээгүй, мэргэжлийн бус хүмүүс учир сэтгүүл зүйн үндсэн мөн чанарыг машид бүдүүлгээр зөрчих болсон. Сэтгүүл зүйд хэн нэгнийг гутаан доромжлох, өөрөөс нь зөвшөөрөл авалгүйгээр хэн нэгнийг нэр устай нь олонд зарлан таагүй дурсамж дурдатгалыг нь сөхөх, үхсэн хүнийг сайн муугаар хэлэх, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх зэрэг нь байж болохгүй зүйл¹ хэмээн бичиж байсан байна.

Sonin.mn 2016.01.13 Б.Замилангийн “Монгол Тулгатны зуун Эрхэм” нэвтрүүлгийн талаарх миний шүүмжид: *...Үзэгчдийг уйдаахгүй байх талаас бодож эвлүүлсэн нэвтрүүлгийн динамик нь яах аргагүй Монголын хувь хувьсгалын олон телевизүүдээр гардаг улиг болсон шоу нэвтрүүлгүүдээс шинэлэг, сонирхолтой гэдэгтэй олонх маргахгүй болов уу. Гэвч магтаалдаа бялуураад нэвтрүүлгийн баг балрав уу эсвэл бүрдсэн багийнхны потенциал шавхагдаад дууссан уу бүү мэд, сүүл рүүгээ хэтэрхий эрээ цээргүй, ёс суртахуунгүй, нийгмийг соён гэгээрүүлэхээсээ илүү хөшигний ард үлдвэл зохих шалиг самуун яриа хөөрөөгөөр дүүрсэн, улс эх орондоо бахдам сайхан гавьяа түүхээ үлдээгээд бурхны оронд заларсан олон буурлын ясыг өндөлзүүлсэн, олон сөрөг шинжийг агуулсан гудамжны бичлэгийн эвлүүлэг болж хувирсан² гэжээ.*

baabar.mn Нийтлэлч Төрмөнх 2017.3.20 ... *Найруулагч Баатар “Монгол тулгатны 100 эрхэм”-ийг мэргэжлийн сэтгүүлчээр хөтлүүлэ-*

хийн оронд Н.Жанцанноров Б.Лхагва-сүрэн, П.Анужин, Н.Сувдаа гэх мэт сэтгүүлч бус хүнийг сонгодог ажээ. Яагаад гэвэл ихэнх мэргэжлийн сэтгүүлчид хуучин стандартын буюу албан хэв яриатай эсвэл тийм дадалтай байдаг гэнэ. Тэрээр өөрийгөө ч дүгнэхдээ “Би ч гэсэн өөрөө л өөрийгөө бүтээж л яваа хүн биз дээ... Сургуульд сураагүйн нэг сайн тал нь хайрцагт ороогүй байдагт юм шиг. Анх “Боролдой” студид зураачаар ажиллаж байхдаа олон нэвтрүүлэг хийлцдэг байлаа. Тэр үед телевизийнхэн яг амьтай, үнэн хэсгийг нь монтажаар тайрч хаяад хөндий хүйтэн, нэг их ухаантай ярьсан хэсгийг оруулаад байхыг анзаарч билээ. Тэгээд энэ хяргаж хаяад байгаа хэсгээр л нэвтрүүлэг хийх ёстой юм байна гэж бодож эхэлсэн. Сэтгэл гэдэг бол ухаанаас хамаагүй мөн чанартай зүйл юм шиг³ гэсэн байна.

Хамгийн сүүлд буюу 2019 оны 10 дугаар сард бичигдсэн Базарсүрэнгийн Болор-Эрдэнийн \Болушка нийтлэл\ шүүмжид “...Ер нь урлагийн зах зээл жижиг нийгэмд авьяасууд нь мэдлэгт суурилах ёстой сэтгүүлзүй рүү түрж ордгоос гурвалжинг дөрвөлжин болгон үзүүлэх, авлигач хулгайчуудаа уран яруу үгээр хулдаад улс төрийн насыг нь уртасгаж өгөх гэх мэт гажуудал гардаг. Найруулагч Баатарт өөрт нь бол үнэндээ өөрийн гэсэн улс төрийн эдийн засгийн чиг баримжаа байхгүй. Байхаар онолын боловсрол байхгүй, зураач. Байгаа нь төрөлх мэдрэмж, уран сийрэг ухаан, нэмэх нь женкоизм. Нэг биедээ хоёр хүн агуулж байгаа юм уу гэлтэй хачин хурц контрасттай. Түүний иймэрхүү Монголын эзэнт гүрний бахархал, социалист носталжиа, дээр нь капиталист хэв маягтай амьдралын холион бантан бол өнөө-

гийн монгол хүний яг дундаж төлөөлөл. Энэ холион бантан болсон сүнс нь нэвтрүүлэгт нь ч нэвт шингэжээ. Хөлс дусалсан хөдөлмөрийн хүний дүр, нижигнэсэн модерн хөгжлийн эрчмийг харуулахад мань хүний авьяас уг нь хүрэлцэнэ. Сэтгэлгээ нь л хүрэлцэхгүй байх шиг⁴. Энэ мэтээр Монгол тулгатны зуун эрхэм нэвтрүүлгийн агуулга, зорилгод гарч буй гажуудал, сэтгүүл зүйн мэргэжлийн байх шаардлага, ёс зүйн алдаа дутагдлыг бас Баатар найруулагч гэж хэн болохыг шүүн тунгааж бичсэн байна. Мэргэжил яагаад чухал вэ? гэвэл мэргэжлийн ёс зүйн хил хязгаараар тухайн хүний үг хэл, үйл үйлдэл, ёс суртахуун хязгаарлагдаж байдаг л оршино.

Нэг насны найрагч байх, нийгмийн оюун санааг чиглүүлэх хоёрын дунд нэлээдгүй том зай бий гэдгийг эндээс харлаа. Нэвтрүүлгийн хөтлөгч мэргэжлийн байх албагүй ч мэргэшүүлэх шаардлага байсаар байгааг мэргэжлийн бус хүмүүсээр нэвтрүүлэг хөтлүүлдэг телевизүүд анхааралдаа авах цаг болжээ. Мөн мэргэжлийн сэтгүүлчдээ мэргэшүүлэн чадавхжуулж, сонгосон салбарынхаа талаар шинжээчийн хэмжээнд хүртэл мэдлэг боловсролтой болгон бэлтгэж, мэргэжлийн мөн чанар, ёс зүйгээ хамгаалах хэрэгтэй болсныг ч сануулж байна.

Бас нэг эмзэглэл нь элэг нэгт ахан дүүс Өвөр Монголын зочдоос “их гүрний дарамт, хавчлага байдаг эсэхийг шалгаах үзэгдэл. Өмөөрөх сэтгэл, өөриймсөх халаглалдаа автсан тэр хэсгүүдийг “нэвтрүүлгээ сонирхолтой болгохын төлөө оруулчихдаг” харгис гэмээр сонголт нь “Монгол тулганы зуун эрхэм” бүтээлийг мэргэжлийн ёс зүйгүүн дээр хүний эрхийн зөрчилтэй нэвтрүүлэг болгочхов.

Бас болоогүй ээ. Түвшинбаяр аварга, Баттулга ерөнхийлөгч гээд нэвтрүүлэг хөтөлж суух нь дэндүү жижигдсэн томчууд, “мэргэжлийн” байх шалгуурт тэнцэхгүй байх нь олонтой. Явж явж энэ нэвтрүүлгийн амин сүнс нь Анужин байсан юм шиг. Уран цэцэн үгээ хэтийдүүлэн ухаалаг дүр эсгэх, уян наалинхай зангаа хэтрүүлэн гоё сайхандаа итгэх, урьсан зочноосоо илүү өөрийгөө илэрхийлэх гээд байдгийг нь эс тооцвол уг нэвтрүүлгийн философи үзэл санаа, нийгэмд нөлөөлөх нөлөөллийг нь арай алс хардаг байсан юм болов уу?

Эвдэх дуртай, эвдэх авьяастай найруулагч Баатарын ээлж дараалсан эвдэлтүүд ийнхүү хүчээ авсаар шар сонинд ч хэрэглэхгүй үг яриаг телевизийн дэлгэцнээ мөнхөлж, ирээдүйдээ үзүүлэхээр хадгалчихлаа. Энэ цагийн үзэгчид гайхан хүлцээд өнгөрч болох ч ирээдүйн үзэгчид “шигшин зэвүүцэх” цөөнгүй дугаар “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлгийн алтан сан хөмрөгт хадглагдаж, энэ нэвтүүлэг 21 дүгээр зууны эхэн үеийн Монголын нийгмийн оюун санааг хэрхэн яаж эвдэж байсныг гэрчлэн үлдэв.

Өнөөгийн нийгмийг үнэн худал хоёрын дунд төөрсөн, зөв буруугийн баримжаагаа алдсан, сайн мууг ялгаж салгах чадваргүй болтлоо дөжирсөн гэдэгтэй санал нийлэх хүн олон. Ийм саармаг байдалд оруулж, нийгмийн оюун санааг эвдэж буй нэвтрүүлгүүдийн нэг нь “Монгол тулгатны зуун эрхэм” болсонд гүнээ харамсаж байна.

Ингээд харвал “санаачилсан төслөө амжилттай явуулахын тулд, хийсэн нэвтрүүлгээ сонирхолтой болгохын тулд “Монгол тулгатны зуун эрхэм” хэмээн онцолсон Монголчуудын эрхэм хүмүүсийг ашиглаад байна уу даа гэх

эвгүй хардалт ч төрсөн. Олон зүйлийг эвдэж, шинэчилж чаддаг авьяаслаг найруулагч Баатар нэвтрүүлгийн анхны зорилгоо эргэн харж, агуулга мөн чанартаа анхаарч, хүний үг хэл, үйл үйлдлийн хил хязгаар болж байдаг ёс зүй, гоо зүйн хэм хэмжээг барьж, сэтгүүл зүйн наад захын дүрэм журмыг баримталж, өөрийнхөө үзэл бодол, дур зоргыг “эвдэн зогсоож” эргэцүүлэн бодож, мэдлэг ухаарлаа тэлэх хэрэгтэй болжээ. Хувь хүн та өөрийнхөө дотоод ухамсрыг эвдэх зориг гаргахгүй бол Монголын сэтгүүл зүйн мэргэжлийн байх, ёс зүйтэй байх хил хязгаарыг үгүй хийж, Монголын нийгмийн оюун санааны төлөвшилд гарз хохирол учруулах нь байна.

2. *“Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монголын нийгмийн оюун санааны хил хязгаар биш харин Баатар найруулагчийн болон түүний багийн мэдлэг боловсролын хил хязгаар гэдгийг сануулахын учир нь:*

“Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монголын нийгмийн оюун санааны оюунт хил хязгаар биш харин Баатар найруулагчийн болон түүний багийн мэдлэг боловсролын хил хязгаар төдий бүтээл гэдгийг мартаж болохгүй. Мартаж хэн хүний хэлсэн үг, санасан санааг ямар ч шүүлтүүргүйгээр тархи, зүрх рүүгээ юүлсээр байвал таны гэх оюун санаа үгүй болж, таны болон бусдын оюун санаа итгэл үнэмшлийн уулзвар болж байх учиртай нийгмийн оюун санааг нэг хүн, хэсэг бүлэг этгээд удирдан чиглүүлэх болно. Фэйсбүүкийн тохируулга таны таашаадаг мэдээллийг, таны дэмждэг хүмүүсийн постыг сонгон танд харуулсаар байдаг шиг “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг таны үнэт зүйлсийг заан чиглүүлсээр байх болно. Бид сайн дүрс,

алдартай хүмүүсийн хөтлөлт, сонирхолтой хэлбэр хийц, хувь хүний байгалийн өгөгдөлд ташааран хууртсаар байх болно. Энэ талаар хамгийн үндэслэлтэй сайн шүүмжийг нийтлэлч Болор-Эрдэнэ бичсэн. Тэрээр: *Баатар улстөрийн эдийн засгийн хувьд өнөөгийн монголчуудын арифметик дундаж болохоос маргааш зорих хөгжлийн хязгаар, үзэл санааны идиал заах чадахгүй байна. Болоод өнгөрснийг сайхнаар үзүүлэхэд авьяас хэрэгтэй. Болох чанадыг зааж үзүүлэхэд харин нэмээд боловсрол, итгэл үнэмшил, үнэт зүйл хэрэгтэй. Цаашид зааж чадах эсэх нь өөрөө ийм сул талаа хүлээн зөвшөөрөх эсэхээс хамаарах биз. Үнэндээ бол парламентын ардчилал бүхий чөлөөт зах зээл гэдэг нь Баатар шиг дор бүрнээ Чингис хааны эгэтой монгол хүн дур зоргоороо давхих шинэ цагийн тал нутаг юм. Гэтэл ерөнхий найруулагчаасаа эхлээд дарангуйлал сурталдаж, өнгөрснөөс зууралдах маягийн үнэт зүйлийн зөрчилд байгаа нь бидний өнөөдрийн ерөнхий дүр төрх мөнөөсөө мөн. Мөнөөх эзэнт гүрэн нь үнэндээ бол ганц Чингис хааны биш цэргийн ардчилал, Их Хурилдай гэх парламентын түүх. Хүний ой санамж гэдэг үнэнд биш домогт дурлах юм. Бүгд л домогт баатрыг санаж үлдэнэ, системийг мартана. Тэрхүү хэлтгий ой санамжаасаа болоод системийг*

*хөгжүүлэх өөрийн үүрэг хариуцлагаа умартаж, ирээд авраад өгөх хүчтэй баатар хүсэмжилнэ. Түүнийг нь Баатар Баттулга хоёр сайхан ашиглана*⁵. хэмээн бичсэн байна.

Үзэж сонирхдог ганц нэвтрүүлгээ бүр дорд орчихоос нь өмнө хэлж, ярьж, зорилгоосоо хазайж болохгүйг нь сануулах хэрэгтэй боллоо. “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг нэр шигээ эрхэм зуун хүний оюун санааны охь шим байх ёстой. Бид үнэнч үзэгч байхаас гадна бас мэдлэг боловсролтой, өөрийн гэсэн бодол ухааралтай, итгэл үнэмшил үнэт зүйлтэй үзэгчид болох хэрэгтэй байна. Дахин хэлье. “Монгол тулгатны зуун эрхэм” Монголын нийгмийн оюун санааны хил хязгаар биш харин Баатар найруулагчийн болон түүний багийн оюунт чадамжийн хил хязгаар юм

шүү

»

хүлээх үүрэг хариуцлага, нийгмийн оюун санааны төлөвшилд нөлөөлж буй нөлөөллийг дүгнэн харах иргэний үүрэг, оюуны чадамж хэрэгтэй байна.

“Монголын зуун эрхэм хүний нэг нь та” хэмээн онцолж урьсан зочдынхоо амьдралын үнэнийг уудлах гэж байгаа бол тухайн цаг үедээ буруу байсан ч, хэцүү байсан ч Монголын сайн сайхны төлөө, монголчуудын ирээдүйн сайн сайхны төлөө өөрийгөө золиослох зориг гаргасан тэр нэг эрхэм нандин шийдвэр,

үйл хэрэг, үг яриа, түүх дурсамжийн үнэнийг уудлан гаргавал юутай үнэ цэнтэй.

“Монголын зуун эрхэм хүний нэг нь та” хэмээн онцолж урьсан зочдынхоо ажил амьдрал, үйл хэрэг, үзэл бодлын тусгалыг “нийгмийн оюун санааны төлөвшил, улс орны хувь заяатай холбон харж, эерэг сайн нөлөөллийг нь гурван цагийг хэлэх цаг хугацааны шалгуур, гурван сая Монголчуудын оршиж үлдэхийн утга дээр зангидан харж, яагаад энэ хүн Монгол тулгатны зуун эрхэмийн нэг болох учиртайг баталж чадвал нийгэмд үзүүлэх үлгэр жишээ болно. Үнэнийг бүтээх, үнэнийг үлдээх нэвтрүүлгийн тань үнэ цэнэ энэ юм. Ингэж байж уран бүтээлийн багийн өмнөө тавьж байсан анхны зорилго болох: “Хоёр зууныг дамжин Монголын түүхийг бичилцсэн нэр алдартай хүмүүсийн амьдралын түүхийг залуу үеийнхэндээ хэлж, ойлгуулан үлдээх зорилго”⁶ тань биеллээ олно. Сонирхолтой байх нь нэг номер уу, хувь хүний үнэн чухал уу? нийгмийн гишүүн, улсын иргэнийхээ хувьд хэлсэн үг хийсэн үйлдлийн үнэн мөн чухал уу? гээд чухлын эрэмбэ дарааллаа эргэн харах цаг болжээ.

“Монгол тулгатны зуун эрхэм” хэмээсэн нэртэйгээ ижил том үзэл баримтлал, том оюун санаа, том алсын хараатай ажиллах болтугай. Нэмж хэлэхэд: заавал уйлуулах гэж зүтгэдэг, замбараагүй явдлыг онцлон дөвийлгөдөг, засаглалын тухай хүчээр хэлүүлдэг “гурван З”-гээсээ салаарай. Монголын нийгмийн оюун санааны задралыг хурдлуулах биш зогсоох хүч болж, оюун санааны итгэл үнэмшил, үнэт зүйлсийн луужин баймаар байна. Нэвтрүүлгийн багт ийм хэмжээний мэдлэг ухааны чадамж байгаа гэдэгт итгэе. Адаг сүүлд нь

сануулахад улс төрийн үзэл хандлагын тулгалт, “хэн нэгний ард түмнээ хуурах” улс төржсөн технологийн золиос битгий болчоосой.

Монголчуудын эрхэмлэн үздэг “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг нэг хүний ажил үйл, үзэл хандлага нийтийн сэтгэл сэтгэлгээ, нийгмийн оюун санаанд хүчтэй нөлөөлж болдог гэдгийг батлан харуулсан бүтээл юм. Тиймээс бид Баатар найруулагчийн тухай бичдэг. Түүнээс түүний багаас илүү хариуцлагатай байхыг хүсэн хүлээдэг. “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монголын нийгмийн оюун санааны төлөвшилд шууд нөлөөлөхүйц жинтэй бүтээл учраас бид энэ нэвтрүүлгийн үзэл санаа, зорилго агуулгыг хянаж байх үүрэгтэй. Соёл урлагийн салбарынхан гоо зүйн нөлөөллийг, сэтгүүл зүйн салбарынхан мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг, тухайн хүний үг хэл, үйл үйлдэл, нийгмийн оюун санааг хааш нь хөтөлж буйд ач холбогдол өгч, задлан шинжилж, нэгтгэн дүгнэдэг байя. “Монгол тулгатны зуун эрхэм” нэвтрүүлэг Монгол хүний эрхэмлэн нандигнах зуун түүх, монгол хүний итгэл найдварыг зуу зуун жил тэтгэх эрч энерги, монголчуудыг зуу зуун жил нэгтгэх оюун санаа, ой санамж нь байгаасай.

Эшлэл

- ¹ Өдрийн сонин 2015.07.24
- ² <http://www.sonin.mn/agency/p/2>
- ³ <http://www.baabar.mn/turmunkh>
- ⁴ <http://www.trends.mn/profile/24>
- ⁵ <http://www.trends.mn/profile/24>
- ⁶ <http://www.ugluu.mn/4723.html>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2015. Сэтгүүл зүйн нэр томъёоны тайлбар толь. УБ.
2. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг С.Лувсангомбо

3. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг Х.Баттулга
4. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг Б.Баасанжав
5. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг Ш.Бира
6. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг Боржигон Гэрэлт
7. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг: Б.Жамъяндагва
8. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг: Д.Амбасэлмаа
9. “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг: Д.Лувсаншарав

Summary

This article discusses about TV program, the “Mongol tulgatny 100 erkhem”, which is a famous personality profile in Mongolia. The author criticizes this program as an angle of journalism ethics and its’ influence for social minds of the Mongolian communities.